



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Төв аймгийн орон нутгийн өмчөөс  
2019 онд хувьчлах эд хөрөнгийн  
жагсаалтын тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төв аймгийн орон нутгийн өмчөөс 2019 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор дэмжсүгэй.

2. Жагсаалтад заасан эд хөрөнгийг хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргалд зөвлөмж болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД

0000100

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны  
04 дүгээр сарын 04 ны өдрийн дугаар тогтоолын  
хавсралт



**Төв аймгийн орон нутгийн өмчөөс 2019 онд хувьчлах эд хөрөнгө**

д/д	Хувьчлах эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн олж авсан арга, хэлбэр, эрхийн акт, дугаар он сар өдөр	Байршил, Харьяалал	Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт	Хувьчлах эд хөрөнгийн дүн /ААН бол нийт хөрөнгөөс өр төлбөр хассан дүнгээр, үл хөдлөх хөрөнгө бол балансын үлдэгдэл үнэ/ /мян.төг/	Хувьчлах хугацаа	Хувьчлах арга, хэлбэр
1	Дулааны хуучин станц	УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоол	Зуунмод сум 5 дугаар баг "Төв Чандмань-ДЭХГ" ОНӨААТҮГ	Дулааны станц	1,100,000.0	III-IV улиралд	Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах
2	Хүмүүн цогцолборын бага сургуулийн "Б" байр	УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоол	Зуунмод сум 2 дугаар баг Засаг даргын Тамгын газар	Бага сургууль	19.4	II улиралд	Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах